



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70512121, 70518232

2020.01.15 № 7/60
танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

“Бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбарын төсөл”-тэй танилцлаа.

Бид дараах саналыг өөрийн аймгийн зүгээс хүргүүлж байна.

1. Сүхбаатар аймаг нь хүрэн нүүрсний их хэмжээний нөөцтэй. Зөвхөн “Дорнын чулуулаг” компанийн Ерөөлтийн уурхай гэхэд 850 сая тн хүрэн нүүрсний нөөцтэй ба үйл ажиллагаагаа эхлэх бэлтгэл ажлаа хангаж байна. Иймд хүрэн нүүрсийг хэрхэн боловсруулж экспортлох талаар бодлого тусгах

2. Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутаг дахь Хөөтийн аж үйлдвэрийн парк байгуулах төслийг Засгийн газрын хуралдаанаар дэмжсэн бөгөөд энэхүү төслийг 2020-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгах

3. Дээрх төслүүдтэй уялдан эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг бий болгох шаардлагатай. Эрчим хүчний шинэ эх үүсвэр Сүхбаатар аймагт байгуулах талаар хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгах

4. Өнгөрсөн жилүүдэд Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд “Үйлдвэр технологийн парк” байгуулах үйл ажиллагааг эхлүүлсэн. Үүнийг олон улсын стандартад нийцсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох боломжтой парк болгон өргөтгөх үйл ажиллагааг 2020-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий чиглэлд оруулан тусгах

5. Монгол улсын эдийн засгийн микро бүсийг тогтоосон байна. Манай аймгийн Эрдэнэцагаан сум нь 6800 хүн амтай, олон улсын байнгын ажиллагаатай Бичигт боомт 70км-д зайд оршдог учир ачаа болон зорчигч тээвэр, дамжин өнгөрөгчдийн тоо жилээс жилд өсөж буй томоохон суурин газар юм. Иймд Эрдэнэцагаан сум нь тусдаа “Эдийн засгийн микро бүс” байхаар тусгах

6. Сүхбаатар аймгийн Мэргэжил сургалтын үйлдвэрлэлийн төвийг хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр бүсийн хэмжээний мэргэжилтэн бэлтгэдэг байгууллага болгон хөгжүүлэх



Ж.ЭРДЭНЭБААТАР

0000010